

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Очирпагма	Дугаар	L259
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баяндэлгэр сум
Төрсөн газар	Баяндэлгэр сум	Төрсөн он	1910
Ажил мэргэжил	Өндөр настан, эмэгтэй		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баяндэлгэрийн хурал	Сүм хийдийн дугаар	ТӨБД 053
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 10-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Төв аймгийн Баяндэлгэр сумын Баяндэлгэрийн хурал

Мөнхбат: Хуучин Түшээт хан аймгийн Дархан Чин ван Пунцагцэрэнгийн хошуу буюу одоогийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт академич Ренчин гуайн жагсаалтанд орсон шарын шашны сүм хийд хурал номын газруудаас Баяндэлгэрийн хурал хэмээх энэ газрын тухай сурвалжлагыг бид нар өнөөдөр хийж байна. Тэгэхээр энэ Баяндэлгэрийн хурал хэмээх энэ хурал номын газар одоогоор Баяндэлгэр сумын төв дээр байсан гэж академич Ринчен гуайн жагсаалтанд бүртгэгдсэн байдаг. Тэгэхээр өнөөдөр энэ хурлын тухай ярилцахаар Төв аймгийн Баяндэлгэр сумын төв дээр оршин суугаа өндөр настан, эдүгээ 97 насыг зооглож байгаа Очирпагма гуайтай бид нар дараах ярилцлагыг үргэлжлүүлж байна. За тэгэхээр Очирпагма гуай, бид нар танаас дараах хэдэн асуултыг асууя. Энэ төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дээр Баяндэлгэрийн хурал гэж байсан байх юм аа. Тэгэхээр тэр хурлын бүүр, түүр таны санаж бодож байгаагаар одоо хаана байна вэ, төвийн аль хэсэгт байна вэ?

Очирпагма: Энэ Баяндэлгэрийн хурал гэж байсан юм гэнэ лээ. Би энэ нутагт байгаагүй болохоор...Хуучинг сургууль байсан юм, хүрэн байшин байсан юм. Тэнд байсан л гэж настангууд ярьдаг байсан юм. Манай Баяндэлгэрийн хурал байсан юм гэж ярьдаг байсан юм. Тэрнээс ондоо мэдэх юм байхгүй шүү дээ.

Мөнхбат: Тэгэхээр Баяндэлгэрийн хурал гэж цагийн хурал байсан юм болов уу, эсвэл тогтмол хурал байсан юм болов уу, аль нэг хүрэнээс лам нар гарч...?

Очирпагма: Цагийн хурал байсан гэдэг юм.

Мөнхбат: Өвөл намартаа л хурал хурдаг байсан байх, тийм ээ?

Очирпагма: Тийм байх, намрын эхэн сард л голцуу хурдаг байсан байх.

Мөнхбат: Аль хүрэнээс лам нар нь гарч ирж хурдаг байсан юм болов уу?

Очирпагма: Зүүн хүрээ л гэж байсан юм, энэ хавьд байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Хөгшин хүрээ гэж яриад байгаа мөн үү?

Очирпагма: Тийм байх.

Мөнхбат: Тэр Өвгөн хүрээ энэ хавьдаа нэлээн том хүрээ байж дээ?

Очирпагма: Тийм л байж дээ, тэр үед олон хүрээ байдаг байсан болохоор сайн тоодоггүй байж.

Мөнхбат: Баяндэлгэрийн хурал дээр хуралд хурдаг байсан лам нараас таны үеийн одпоо таны мэдэж байсан, таны төрөл садан гэдэг юм уу тийм нутгийн лам нар байсан уу, таны санаж байгаа нэр байна уу?

Очирпагма: Байхгүй юм даа, одоо нэг өвгөн байсан юм. Хэн билээ ...Тэр л хуучин хүрээнд лам байсан юм.

Мөнхбат: Энэ Баяндэлгэрийн хурлын дуган модон дуган байсан юм болов уу, гэр дуган байсан юм болов уу?

Очирпагма: Модон дуган байсан юм.

Мөнхбат: Хэдэн дуган байсан юм бол?

Очирпагма: Нэг л том хүрэн дуган байсан юм. Сургууль байсан юм, хүүхэд сууж байхад...

Мөнхбат: Тэгээд тэр дуганыг хэдий үед нурааж устгасан байдаг юм бол, сүүлд хожуу нурааж буулгасан байдаг юм байх даа ?

Очирпагма: Өө хойно , энэ урд Баяндэлгэрийг татан буулгана гэж яагаад, энэ хойно Тариатыг яана гэж.буулгаад бүр оргүй, суурьгүй ганцхан хүрэн жоохон байшин захиргаа нь гэж байгаад байхгүй болгоод нураачихсан юм.

Мөнхбат: Тэр сүм хийд эзгүйрээд лам нарыг нь ингээд хурал хурахаа больчихсон хойно тэр Баяндэлгэрийн дуган одоо нураалгүй байж байхдаа дотор нь тэр бурхан шашин ном судрыг нь устгачихсан байсан юм болов уу?

Очирпагма: Устгачихсан байсан.

Мөнхбат: Тэгээд дуган бол хоосон шувууны үүр болоод шахуу?

Очирпагма: Тэгээд сургууль орсон ухаантай, сургуулийн халуун ус энэ тэр гээд энэ хийдийг бахйгүй болгочихоод байсан юм. Хүүхэд усанд оруулдаг тийм юм байсан юм байгаа биз дээ.

Мөнхбат: Тэр намрын одоо хурлын үеэр, лам нар ирж хурал хурах үеэр энэ хавийн сүсэгтэн олон ирж хуралд суудаг л байсан байх даа?

Очирпагма: Тийм л байсан байх даа.

Мөнхбат: Чухам ямар ямар хурал ном айлддаг байсан юм бол, тэрийг та сонссон барьсан юм байна уу?

Очирпагма: Мэдэхгүй.

Мөнхбат: Энэ Баяндэлгэр сумаас урагшаа, одоо зүүн урагшаа Баянжаргалан сүм гэж байна, тийм ээ. Баянжаргалангийн сумын хурал номын тухай та бас зарим зүйлийг мэднэ дээ?

Очирпагма: Халтар хултар мэднэ л дээ. Бас мүнхраад зарим зүйлийг мартаж. Уул нь Баянжаргалангийн нутаг чинь өдгөө манай нутаг л байсан юм.

Мөнхбат: Ямар ямар хурал номын газар байсан юм бол оо?

Очирпагма: Цагийн хурал байсан юм, Шандын хурал гэж намар намрын дунд сард л хурдаг тийм хурал байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Би тэгэхээр Баянжаргалан сумын нутаг дахь хурал номын газруудыг танд хэлвэ. Юншийн хурал гэж та сонссон уу, Юншийн хурал Бөөрийн жас гэж?

Очирпагма: Юншийнхан гэж энэ баруун хойд талынхныг хэлдэг. Одоо бол Баянжаргалангийн баруун хойд тал л юм даа. Юншийнхан гэж тэднийхнийг хэлдэг юм.

Мөнхбат:Тэнд бас нэг хурал номын газар байсан байгаа юм аа. Юншийн хурал гэж?

Очирпагма: Юншийн хурал гэж байсан юм гэнэ лээ. Би бас тэрийг сайн мэдэхгүй. Тэр Шандын хурлыг бодл халтар хултар мэднэ.

Мөнхбат: Тэр нялга гэдэг газар Модонгийн хурал гэж байсан байна уу?

Очирпагма: Тэр Цэцэн вангийнхаа хошуунд байсан юм гэнэ лээ. Модонгийн хурал гэж ярьдаг юм.

Мөнхбат: Одоогийн Хэнтий тал руугаа орж байна уу, үгүй юу? Баянжаргалангийн нутаг уу?

Очирпагма: Одоо Баянжаргалангийн нутаг юм уу даа, юуны ч нутаг юм. Хуучин нутгийн дээсээр бол манайх Шавийн нутаг.

Мөнхбат: Алтадын хурал гэж?

Очирпагма: Алтадын хурал гэж баруун тийшээгээ л ярьдаг байх.Мэдэхгүй, тэрнийг.

Мөнхбат: Та тэр Сантын хурлынхаа талаар та тодруулж яриач, одоо ямар нэртэй газар байна, Баянжаргалан сумынхаа хэддүгээр багийн нутагт байсан юм?

Очирпагма: Одоо тэр Зөөлөнгийн шар овоо гэж байдаг юм.